

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/14/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН 2023 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273204 Цахим хаяг: [byambatsogtj@audit.gov.mn](mailto:byambatsogtj@audit.gov.mn)



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Товчилсон үгийн жагсаалт .....	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.5.1 Завсрын аудитын талаар .....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	20
5.1 Зөвлөмж .....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	22

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АҮТХ	Ажил үйлчилгээний төлбөр хураамж
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ШШЕГ	Шүүхийн шинжилгээний ерөнхий газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.22 № 01/43

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Шүүх шинжилгээний тухай шинэчилсэн хуулийг 2023 оны 01 сарын 01-ээс мөрдөн ажиллаж эхэлсэнтэй холбоотой Төв аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтэс болон өөрчлөгдөж Шүүхийн шинжилгээний ерөнхий газарт харьяалагдах болсон байна.

**Аудитын гол асуудал**

Цалингийн сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл 426.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэлгүй ахмадын санд төвлөрүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

019020076

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,401,128.6	10,030,038.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	781,588.6	452,588.6
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	781,588.6	452,588.6
3121	Төгрөг	781,588.6	452,588.6
31211	Төрийн сангийн харилцах	781,588.6	452,588.6
35	БАРАА МАТЕРИАЛ	9,619,540.0	9,577,450.0
351	Түүхий эд материал	3,387,200.0	1,590,400.0
35130	Эм боох материал	3,387,200.0	1,590,400.0
354	Хангамжийн материал	6,232,340.0	7,987,050.0
35420	Аж ахуйн материал	6,232,340.0	7,987,050.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	74,835,182.2	135,707,424.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	74,835,182.2	135,707,424.3
392	Биет хөрөнгө	65,235,182.2	126,107,424.3
39203	Авто-тээврийн хэрэгсэл	70,940,572.5	70,940,572.5
39204	Хуримтлагдсан элэгдэл	-43,956,728.9	-46,781,729.0
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	87,558,407.6	110,195,972.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-54,044,952.3	-15,223,594.9
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,292,325.8	8,679,378.4
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,554,442.6	-1,703,174.7
393	Биет бус хөрөнгө	9,600,000.0	9,600,000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	9,600,000.0	9,600,000.0
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>85,236,310.7</b>	<b>145,737,462.9</b>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	85,236,310.7	145,737,462.9
51	Засгийн газрын хувь оролцоо	85,236,310.7	145,737,462.9
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	33,056,987.0	33,056,987.0
51101	Өмч: - төрийн	33,056,987.0	33,056,987.0
512	Хуримтлагдсан үр дүн	52,179,323.8	112,680,475.9
51210	Өмнөх үеийн үр дүн	52,179,323.8	52,179,323.8
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	60,501,152.1
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>85,236,310.7</b>	<b>145,737,462.9</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>323,119,013.7</b>	<b>539,225,628.4</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,596,513.7	25,494,428.4
120	Нийтлэг татварын бус орлого	26,596,513.7	25,494,428.4
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,841,000.0	24,644,470.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,841,000.0	13,118,000.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.0	11,526,470.0
120009	Бусад орлого	773,119.0	426,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	296,522,500.0	513,731,200.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	291,485,000.0	492,292,200.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	291,485,000.0	492,292,200.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,037,500.0	21,439,000.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	19,900,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,037,500.0	1,539,000.0
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>319,121,255.3</b>	<b>478,724,476.3</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	319,121,255.3	478,724,476.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	316,468,341.3	443,439,620.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223,221,099.1	336,676,476.1
210101	Үндсэн цалин	101,144,400.0	190,931,948.2
210102	Нэмэгдэл	97,319,400.0	104,760,844.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,835,799.1	20,849,784.2
210104	Урамшуулал	1,921,500.0	20,133,898.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,193,798.4	10,353,199.3
210201	Тэтгэврийн даатгал	509,699.6	2,019,899.3
210202	Тэтгэмжийн даатгал	59,999.6	247,494.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	47,999.4	205,800.5
210204	Ажилгүйдлийн даатгал	11,999.6	105,500.9
210205	Эрүүл мэндийн даатгал	4,564,100.2	7,774,504.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,229,470.5	16,171,742.7
210301	Гэрэл, цахилгаан	2,042,811.0	2,412,150.5
210302	Түлш, халаалт	8,058,019.5	9,688,068.2
210303	Цэвэр, бохир ус	4,448,640.0	1,701,524.0
210304	Байрны түрээс	1,680,000.0	2,370,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	23,592,240.0	26,913,190.0
210401	Бичиг хэрэг	3,038,770.0	2,732,160.0
210402	Тээвэр, шатахуун	16,417,460.0	21,000,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,255,190.0	1,108,600.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	236,000.0	240,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,644,820.0	1,832,430.0
2105	Нормативт зардал	10,992,640.0	13,944,362.0

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,944,640.0	12,155,562.0
210502	Хоол, хүнс	0.0	1,339,800.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	48,000.0	449,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,167,790.0	12,485,300.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	237,800.0	753,000.0
210604	Урсгал засвар	7,929,990.0	11,732,300.0
2107	Томилолт, зочны зардал	9,003,000.0	10,292,000.0
210702	Дотоод албан томилот	9,003,000.0	10,292,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,261,344.0	5,408,164.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	750,600.0	713,500.0
210803	Даатгалын үйлчилгээ	153,750.0	525,300.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	223,454.0	72,964.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.0	53,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.0	4,000,000.0
210807	Газрын төлбөр	78,540.0	43,400.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,806,959.3	11,195,186.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,457,500.0	0.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,349,459.3	11,195,186.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,652,914.0	35,284,855.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	680,000.0	33,625,700.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.0	755,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	21,208,200.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	680,000.0	11,662,500.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	1,659,155.9
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	1,659,155.9
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,972,914.0	0.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,997,758.4	60,501,152.1
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	246,000.0	0.0
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	246,000.0	0.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-246,000.0	0.0
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>3,751,758.4</b>	<b>60,501,152.1</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>303,136,619.0</b>	<b>527,275,200.0</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,614,119.0	13,544,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	6,614,119.0	13,544,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,841,000.0	13,118,000.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,841,000.0	13,118,000.0
120009	Бусад орлого	773,119.0	426,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	296,522,500.0	513,731,200.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	291,485,000.0	492,292,200.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	291,485,000.0	492,292,200.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,037,500.0	21,439,000.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	19,900,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,037,500.0	1,539,000.0
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>303,043,500.0</b>	<b>467,487,200.0</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	303,043,500.0	467,487,200.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	300,390,586.0	432,202,344.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223,221,099.1	336,676,476.1
210101	Үндсэн цалин	101,144,400.0	190,931,948.2
210102	Нэмэгдэл	97,319,400.0	104,760,844.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,835,799.1	20,849,784.2
210104	Урамшуулал	1,921,500.0	20,133,898.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,193,798.4	10,353,199.3
210201	Тэтгэврийн даатгал	509,699.6	2,019,899.3
210202	Тэтгэмжийн даатгал	59,999.6	247,494.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	47,999.4	205,800.5
210204	Ажилгүйдлийн даатгал	11,999.6	105,500.9
210205	Эрүүл мэндийн даатгал	4,564,100.2	7,774,504.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,178,264.5	16,171,742.7
210301	Гэрэл, цахилгаан	2,042,811.0	2,412,150.5
210302	Түлш, халаалт	8,058,019.5	9,688,068.2
210303	Цэвэр, бохир ус	4,397,434.0	1,701,524.0
210304	Байрны түрээс	1,680,000.0	2,370,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	20,341,500.0	27,955,400.0
210401	Бичиг хэрэг	2,702,200.0	2,750,000.0
210402	Тээвэр, шатахуун	13,162,700.0	21,000,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,255,200.0	1,108,600.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	236,000.0	240,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,985,400.0	2,856,800.0
2105	Нормативт зардал	14,057,830.0	12,339,362.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,105,130.0	10,499,562.0
210502	Хоол, хүнс	0.0	1,339,800.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	952,700.0	500,000.0

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,586,350.0	13,260,300.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	591,360.0	655,000.0
210604	Урсгал засвар	7,994,990.0	12,605,300.0
2107	Томилолт, зочны зардал	9,003,000.0	10,292,000.0
210702	Дотоод албан томилолт	9,003,000.0	10,292,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,351,244.0	5,153,864.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	840,500.0	459,200.0
210803	Даатгалын үйлчилгээ	153,750.0	525,300.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	223,454.0	72,964.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.0	53,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.0	4,000,000.0
210807	Газрын төлбөр	78,540.0	43,400.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,457,500.0	0.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,457,500.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,652,914.0	35,284,855.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	680,000.0	33,625,700.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.0	755,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	21,208,200.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	680,000.0	11,662,500.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	1,659,155.9
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	1,659,155.9
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,972,914.0	0.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	93,119.0	59,788,000.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.0	60,117,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	60,117,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	60,117,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.0	60,117,000.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.0	-60,117,000.0
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>93,119.0</b>	<b>-329,000.0</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	688,469.6	781,588.6
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	781,588.6	452,588.6

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,056,987.0	-	48,427,565.3	81,484,552.3
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,056,987.0	-	48,427,565.3	81,484,552.3
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	3,751,758.4	3,751,758.4
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,056,987.0	-	52,179,323.8	85,236,310.7
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,056,987.0	-	52,179,323.8	85,236,310.7
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,056,987.0	-	52,179,323.8	85,236,310.7
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	60,501,152.1	60,501,152.1
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,056,987.0	-	112,680,475.9	145,737,462.9

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>503,792,200.0</b>	<b>503,751,044.1</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	503,792,200.0	503,751,044.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	470,921,500.0	470,880,344.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	336,676,700.0	336,676,476.1
210101	Үндсэн цалин	192,215,200.0	190,931,948.2
210102	Нэмэгдэл	103,157,900.0	104,760,844.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,880,000.0	20,849,784.2
210104	Урамшуулал	20,423,600.0	20,133,898.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,353,200.0	10,353,199.3
210201	Тэтгэврийн даатгал	2,019,900.0	2,019,899.3
210202	Тэтгэмжийн даатгал	250,600.0	247,494.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	205,800.0	205,800.5
210204	Ажилгүйдлийн даатгал	105,500.0	105,500.9
210205	Эрүүл мэндийн даатгал	7,771,400.0	7,774,504.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,869,900.0	15,849,742.7
210301	Гэрэл, цахилгаан	2,500,800.0	2,412,150.5
210302	Түлш, халаалт	9,365,800.0	9,366,068.2
210303	Цэвэр, бохир ус	1,633,300.0	1,701,524.0
210304	Байрны түрээс	2,370,000.0	2,370,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	27,969,600.0	27,955,400.0
210401	Бичиг хэрэг	2,750,000.0	2,750,000.0
210402	Тээвэр, шатахуун	21,000,000.0	21,000,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,122,800.0	1,108,600.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.0	240,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,856,800.0	2,856,800.0
2105	Нормативт зардал	12,339,800.0	12,339,362.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	10,500,000.0	10,499,562.0
210502	Хоол, хүнс	1,339,800.0	1,339,800.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.0	500,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,261,000.0	52,260,300.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	39,000,000.0	39,000,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	655,000.0	655,000.0
210604	Урсгал засвар	12,606,000.0	12,605,300.0
2107	Томилолт, зочны зардал	10,292,000.0	10,292,000.0
210702	Дотоод албан томилолт	10,292,000.0	10,292,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,159,300.0	5,153,864.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	459,200.0	459,200.0
210803	Даатгалын үйлчилгээ	525,300.0	525,300.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	78,400.0	72,964.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	53,000.0	53,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.0	4,000,000.0
210807	Газрын төлбөр	43,400.0	43,400.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,870,700.0	32,870,700.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,870,700.0	32,870,700.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,208,200.0	21,208,200.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,662,500.0	11,662,500.0
<b>0</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>503,792,200.0</b>	<b>505,410,200.0</b>
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	492,292,200.0	492,292,200.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	492,292,200.0	492,292,200.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,500,000.0	13,118,000.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,500,000.0	13,118,000.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2022 он	2023 он
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,037,500.0</b>	<b>21,439,000.0</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,037,500.0	21,439,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,037,500.0	21,439,000.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,680,000.0	322,000.0
210302	Түлш, халаалт	0.0	322,000.0
210304	Байрны түрээс	1,680,000.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	400,000.0	0.0
210401	Бичиг хэрэг	400,000.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	700,000.0	21,117,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0	21,117,000.0
210604	Урсгал засвар	700,000.0	0.0
2107	Томилолт, зочны зардал	800,000.0	0.0
210702	Дотоод албан томилолт	800,000.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,457,500.0	0.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,457,500.0	0.0
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,037,500.0</b>	<b>21,439,000.0</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,037,500.0	21,439,000.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	19,900,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,037,500.0	1,539,000.0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтэс нь эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүх, арбитрын тогтоол, шүүгчийн захирамж, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны хүсэлтэд заасан шинжилгээний объектод тусгай мэдлэгийн хүрээнд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үйл ажиллагааг явуулдаг Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын харьяа байгууллага юм.

2023 оныг “Хууль сахиулах салбарын эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжих, ажиллах нөхцөлийг сайжруулах, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн, өрсөлдөх чадварыг хөгжүүлэх” зорилго дэвшүүлэн 5 зорилт, 47 ажил, арга хэмжээг төлөвлөн ажилласан байна. Дэвшүүлсэн зорилго, зорилт, арга хэмжээг 97,5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж, 12 арга хэмжээг нэмж хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүх, арбитрын тогтоол, шүүгчийн захирамж, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны хүсэлтэд заасан шинжилгээний объектод тусгай мэдлэгийн хүрээнд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах
- Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хөрөнгө, хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ тооцох, сэтгэцэд учирсан хор уршгийн үнэлгээнд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Шүүх шинжилгээний тухай хуулийг 2022 оны 12 сард 11 бүлэг 81 зүйлтэйгээр шинэчлэн баталж 2023 оны 01 сарын 01-ээс мөрдөн ажиллаж эхэлсэн байна. Мөн Төсвийн тухай хуулийн зарим зүйл заалт тухайлбал 8 дугаар зүйл “Төсвийн цагалбар”, 23 дугаар зүйл “Төсвийн орлого”, 24 дүгээр зүйл “Төсвийн зарлага”, 27 дугаар зүйл “Төсвийн төсөлд тавигдах шаардлага”-д өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Тус байгууллагын дотоод хяналт хариуцсан мэргэжилтнээр криминалистикийн ахлах шинжээч ажилладаг бөгөөд нярвын ажлыг хавсран гүйцэтгэдэг байна. Энэ нь дотоод хяналтын хараат бус байдал алдагдахаас гадна ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэл байна гэж үзлээ.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтэс нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын хяналт шинжилгээ, дотоод аудитын хэлтэс гүйцэтгэдэг байна. 2023 онд тус байгууллагын үйл ажиллагаанд ШШЕГ-ын хяналт шинжилгээ, дотоод аудитын газраас аудит хийгээгүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн зорилго оршино. Төв аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс боловсруулан баталж үйл ажиллагаанд нь мөрдүүлэн ажиллаж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 60,501.2 мянган төгрөгөөр буюу 71,0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	781.6	452.6	(329.0)
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	9,619.5	9,577.5	(42.1)
Үндсэн хөрөнгө	74,835.2	135,707.4	60,872.2
Нийт хөрөнгө	85,236.3	145,737.5	60,501.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	85,236.3	145,737.5	60,501.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	85,236.3	145,737.5	60,501.2

Үндсэн хөрөнгө данс 2023 онд машин тоног төхөөрөмж 22,638.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 17,740.0 мянган төгрөг, шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр 38,303.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 60,117.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч, ШШЕГ-аас 8,872.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,078.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 480,292.2 мянга, үйл ажиллагааны орлогоос 10,000.0 мянга, нийт зарлагыг 490,292.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас үндсэн үйл ажиллагааны зардлыг 468,962.3 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн зардлыг 32,870.7 мянга, бусад нийтлэг АҮТХ-ийн зардлыг 459.2 мянган төгрөгөөр хэвээр нь баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 13,500.0 төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 492,292.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 11,500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 492,292.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 13,118.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 503,751.0 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг байр ашиглалттай холбоотой зардал 20.2 мянга, хангамж, бараа материалын зардал 21.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Шүүхийн шинжилгээ-Үндсэн үйл ажиллагааны зардал	470,462.30	470,421.14	41.16	100.0
2	Шүүхийн шинжилгээ-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	32,870.70	32,870.70	-	100.0
3	Шүүхийн шинжилгээ-Шүүхийн шинжилгээний тусгай ажил, үйлчилгээ	459.20	459.20	-	100.0
	Дүн	503,792.20	503,751.04	41.16	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн №30 дугаар тогтоолоор багаж тоног төхөөрөмж худалдан авахад зориулан 19,900.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс давсан орлогоос 1,539.0 мянган төгрөг, нийт 21,439.0 мянган төгрөгийн орлого орсон байна. Нэмэлт санхүүжилтийн орлогоос Халиун проперти ХХК-иас 19,900.0 мянга, Моли элетроникс ХХК-иас 1,217.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж авч, түлш халаалтын өглөгт 322.0 мянган төгрөгийн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70707 /Шүүхийн шинжилгээ/-80101 /Үндсэн үйл ажиллагааны зардал	2023.01.01 2023.12.31	Бие даасан, хараат бус байдлыг хангах, үзлэг, шинжилгээ нэг бүрийн чанарыг нэмэгдүүлэх, хүний нөөцийн чадавхийг сайжруулах, эрх зүйн тогтолцоог бэхжүүлэх, шүүх шинжилгээний нэгдсэн бүртгэл, шинжээчийн дүгнэлт, шинжилгээний объектын бүрэн бүтэн байдлыг хангах гэсэн 5 зорилт, 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.	Шүүх эмнэлэг, криминалистик шинжилгээг хийж, дүгнэлт гаргасан байна. Хэрэгжилт 99,9 хувь	470,462.30	470,421.14
2	70707 /Шүүхийн шинжилгээ/-80802 /Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2023.01.01 2023.12.31	Тэтгэвэрт гарах нэг албан хаагчид болон хөдөлмөрийн дотоод журамд тусгасан нөхцөлд олгох	Тэтгэвэрт гарсан 1 албан хаагчид 21.2 сая төгрөг, албан үүргээ сайн гүйцэтгэсэн албан хаагчдын шагнал, түлээ нүүрсний хөнгөлөлтөд 11.6 сая төгрөг олгосон байна. Хэрэгжилт 100 хувь	32,870.70	32,870.70
3	70707 /Шүүхийн шинжилгээ/-82311 /Шүүхийн шинжилгээний тусгай ажил, үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай ажил үйлчилгээг авах	Шүүхийн шинжилгээний тухай хууль шинэчлэгдэн нэр өөрчлөгдсөнтэй холбоотой тамга, тэмдэг шинэчлэх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж машины дугаар солиулах, санхүүгийн программ хангамжийн эрх сунгуулсан байна. Хэрэгжилт 100 хувь	459.20	459.20
Дүн					503,792.20	503,792.20

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 1 хөтөлбөр, 3 арга хэмжээг 99,9 хувьтай хийж гүйцэтгэсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн 2023 онд Оюу-энд-эн-интернешнл ХХК-иас 19,900.0 мянган төгрөг, Халиун проперти ХХК –иас 14,520.0 мянган төгрөгийн багаж, тогог төхөөрөмж худалдан авсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах нягтлан бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны үр дүнгийн тайлангийн орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн орлого 323,119.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 4,846.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар зарцуулах үүднээс байгууллагын үйл ажиллагаандаа цахим орчинг бий болгох, ажлын шат дамжлагыг бууруулах, цахимжуулах ажлыг эхлүүлснээр төсөвт тодорхой хэмжээний хэмнэлт бий болж 1,659.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн 2023 оны шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт хийхэд албан хаагчийн шагнасан, ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх, давсан орлого зарцуулахтай холбоотой 2,294.0 мянган төгрөгийн 3 тушаалыг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-д “нийтийн өмчтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актыг боловсронгуй болгох, батлан гаргах талаар эрх бүхий этгээдэд зөвлөмж өгөх” гэсэн заалтыг үндэслэн шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв байршуулж байх зөвлөмж өгөв

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

2023 онд тус байгууллагын үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 1,680.0 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 6 сарын 25-ны өдрийн 1/12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	1,680.0	1	1,680.0	100
<b>Нийт дүн</b>					

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг авч үзэхээр шийдвэрлэв.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 69,203.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 69,203.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

*Залруулсан алдаа:*

- Тэтгэвэрт гарах албан хаагчид олгох тэтгэмж 21,208.2 мянган төгрөгийг өглөг дансанд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Үйл ажиллагааны санхүүжилтээс хэмнэгдсэн зардал 426.0 мянган төгрөгийг ахмадын санд шилжүүлэхдээ орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогын дүн ерөнхий дэвтэр, ерөнхий журналын дүнгээс 1,539.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Цалингаас суутгасан 43,233.1 мянган төгрөгийн НДШ, ХХОАТ-ыг цалингийн өглөг дансанд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд шинээр нэмэгдсэн 43 үндсэн хөрөнгөнд 2,372.7 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн хандиваар болон шилжүүлэн авсан дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан дүнтэй тулгахад 424.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 426.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 426.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

## **5.1 Зөвлөмж**

### **1. Нягтлан бодох бүртгэлийн талаар**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай заалтыг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг цаашид ашиглах боломжтой бол дахин үнэлэх, боломжгүй бол эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

### **2. Төсвийн тухай хуулийн хэрэгжилт**

Батлагдсан цалингийн зардлын төсвөөс зарцуулагдаагүй үлдэгдэл 426.0 мянган төгрөгийн үлдэгдлийг төвлөрүүлэлгүй ахмадын санд төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөв батлуулахдаа ахмадын санд төвлөрүүлэх төсвийг туснаж батлуулж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	
							Тоо	Дүн
Тэтгэвэрт гарах албан хаагчид олгох тэтгэмжийг бүртгэхдээ өглөг дансанд бүртгээгүй	1	21,208.2					1	21,208.20
Тайлант онд 118,636.0 мянган төгрөгийн өртөгтэй 97 үүнээс шинээр нэмэгдсэн 43 үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцоогүй байна.	1	2,372.7					1	2,372.72
Үйл ажиллагааны санхүүжилтээс хэмнэгдсэн зардлыг ахмадын санд шилжүүлэхдээ орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан	1	426.0					1	426.00
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогын дүн ерөнхий дэвтэр, ерөнхий журналын дүнгээс зөрүүтэй тайлагнасан	1	1,539.0					1	1,539.00
Цалингаас суутгасан НДШ, ХХОАТ-ыг цалингийн өглөг дансанд бүртгээгүй	1	43,233.1					1	43,233.11
Бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн хандиваар болон шилжүүлэн авсан дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан дүнтэй тулгахад 424.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	424.0					1	424.00
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>69,203.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>6</b>	<b>69,203.03</b>

### Санхүүгийн тайлангийн зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Батлагдсан цалингийн зардлын төсвөөс зарцуулагдаагүй үлдсэн үлдэгдлийг төвлөрүүлэлгүй ахмадын санд төвлөрүүлсэн.	1	426.0					1	426.00		
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 32,762.0 мянган төгрөгийн өртөгтэй 5 нэр төрлийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	0.0					1	0.0		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>426.0</b>					<b>2</b>	<b>426.0</b>		

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Албан хаагчийн шагнасан, ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх, давсан орлого зарцуулахтай холбоотой тушаалыг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна.	1	2,294.0						1	2,294.0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2,294.0</b>						<b>1</b>	<b>2,294.0</b>